

“ХАР ХОРУМ ПРОПЕРТИЙС” ХК

2020 оны 03 дугаар сарын 06-ны өдөр

№ТУЗТ 03/2020

Улаанбаатар хот

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

Охин компани үүсгэн байгуулах, компанийн энгийн хувьцаа худалдан авах, данс нээх тухай

Компанийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсэг, 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсэг, 55 дугаар зүйл, 56 дугаар зүйлийн 56.1 дэх хэсэг, 76 дугаар зүйлийн 76.1.6, 76.1.8, 76.1.15, 76.1.16, 76.1.17, 76.2 дахь хэсэг, 87 дугаар зүйлийн 87.1, 87.2 дахь хэсэг, 88 дугаар зүйлийн 88.1 дэх хэсэг, 89 дүгээр зүйлийн 89.1, 89.2 дахь хэсэг, 91 дүгээр зүйлийн 91.2 дахь хэсэг, 92 дугаар зүйлийн 92.1 дэх хэсэг, “Хар хорум пропертийс” ХК (“Компани”)-ийн дүрмийн 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсэг, 21 дүгээр зүйлийн 21.1 дэх хэсэг болон Төлөөлөн удирдах зөвлөлийн 2020 оны 03 дугаар сарын 06-ны өдрийн ээлжит бус хурлын шийдвэрийг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Компанид нэгдэн орж буй “Эрдэнэс сольюшинс” ХХК-ийн санхүүгийн тайланг 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн эцсийн байдлаар тасалбар болгон нэгтгэн гаргаж, тасалбар болгосон өдрөөс хойш “Хар хорум пропертийс” ХК болон “Эрдэнэс сольюшинс” ХХК дээр гарсан гүйлгээг 2020 оны 3 дугаар сарын 31-ний өдрийн дотор “Хар хорум пропертийс” ХК-ны санхүүгийн тайланд тусгасугай.
2. Компанийн Гүйцэтгэх захирлаар Монгол Улсын иргэн Цогтбаяр овогтой Хүдэрмөнхийг томилсугай.
3. Компанийн Гүйцэтгэх захирал Ц.Хүдэрмөнхтэй байгуулах Контрактын гэрээг энэхүү тогтоолын 1-р хавсралтаар баталсугай.
4. Компани “Эйс ассошиэйтс ББСБ” ХХК-ийн 1 /нэг/ ширхэг нь 1,000 /нэг мянга/ төгрөгийн нэрлэсэн үнэтэй 851,000 /найман зуун тавин нэгэн мянга/ ширхэг хувьцааны 85 /наян тав/ хувь буюу 723,350 /долоон зуун хорин гурван мянга гурван зуун тавь/ ширхэг энгийн хувьцаа нэг бүрийг нь 1,202.73 /нэг мянга хоёр зуун хоёр төгрөг далан гурван мөнгө/ төгрөгөөр буюу нийт 869,994,745.50 /найман зуун жаран есөн сая есөн зуун ерэн дөрвөн мянга долоон зуун дөчин таван төгрөг тавин мөнгө/ төгрөгөөр худалдан авах гэрээ хийхийг Гүйцэтгэх захирал (Ц.Хүдэрмөнх)-д даалгасугай.
5. Компани болон “Эйс ассошиэйтс ББСБ” ХХК хооронд байгуулагдах Хувьцаа худалдах, худалдан авах гэрээ, Эрх шилжүүлэх гэрээ болон тэдгээртэй нийцүүлэн гарах аливаа гэрээ, хэлцэл, баримт бичигт Компанийг төлөөлөн гарын үсэг зурах бүрэн эрхийг Гүйцэтгэх захирал (Ц.Хүдэрмөнх)-д олгосугай.
6. Компани “Эрдэнэс коммодитийс трейдинг” ХХК-ийн 1 /нэг/ ширхэг нь 1 /нэг/ төгрөгийн нэрлэсэн 301,000 /гурван зуун нэг мянга/ ширхэг хувьцааны 90 /ер/ хувь буюу 270,900 /хоёр зуун далан мянга есөн зуу/ ширхэг энгийн хувьцаа нэг бүрийг нь 1.18 /нэг төгрөг арван найман мөнгө/ төгрөгөөр буюу 319,662,000 /гурван зуун арван есөн төгрөг зургаан зуун жаран хоёр мянга/ төгрөгөөр худалдан авах гэрээ хийхийг Гүйцэтгэх захирал Ц.Хүдэрмөнхөд даалгасугай.
7. Компани болон “Эрдэнэс коммодитийс трейдинг” ХХК хооронд байгуулагдах Хувьцаа худалдах, худалдан авах гэрээ, Эрх шилжүүлэх гэрээ болон тэдгээртэй нийцүүлэн гарах аливаа гэрээ, хэлцэл, баримт бичигт Компанийг төлөөлөн гарын үсэг зурах бүрэн эрхийг Гүйцэтгэх захирал (Ц.Хүдэрмөнх)-д олгосугай.

8. Энэхүү тогтоолын 4 дэх хэсэг болон 6 дахь хэсэгт заасан компаниудын энгийн хувьцаа худалдан авах хугацаа 2021 оны 6 дугаар сарын 30-ны өдөр хүртэл хүчинтэй байх бөгөөд тус хугацааны дотор компаниудтай гэрээ, хэлцэл байгуулан ажиллахыг Гүйцэтгэх захирал (Ц.Хүдэрмөнх)-д даалгасугай.
9. Компани нь “Эрдэнэс агро энд ресорт” оноосон нэртэй охин компанийг хязгаарлагдмал хариуцлагатай компанийн хэлбэрээр үүсгэн байгуулсугай. Үүнд:
- a. “Эрдэнэс агро энд ресорт” ХХК-ийг нэг бүр нь 1 /нэг/ төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 20,000 /хорин мянга/ ширхэг энгийн хувьцаанаас бүрдэх нийт 20,000 /хорин мянга/ төгрөгийн хувь нийлүүлсэн хөрөнгөтэйгээр үүсгэн байгуулсугай.
 - b. “Эрдэнэс агро энд ресорт” ХХК-ийн нийт гаргасан энгийн хувьцааг Компани нь 100 хувь эзэмшихийг дурдсугай.
 - c. “Эрдэнэс агро энд ресорт” ХХК нь хөдөө аж ахуй, аялал жуулчлал, худалдааны зуучлалын чиглэлээр хугацаагүйгээр үйл ажиллагаа эрхлэхээр шийдвэрлэсүгэй.
 - d. “Эрдэнэс агро энд ресорт” ХХК-ийн Гүйцэтгэх захирлаар Монгол Улсын иргэн Цогтбаяр овогтой Хүэрмэнхийг томилсугай.
 - e. “Эрдэнэс агро энд ресорт” ХХК-ийн албан ёсны хаягийг Монгол Улс, Улаанбаатар хот Чингэлтэй дүүргийн, 3-р хороо, Энх тайваны өргөн чөлөө, 7/2, Денвер оффис, 4-р давхар тоот албан ёсны хаягт байрлан үйл ажиллагаа явуулахаар тогтоосугай.
 - f. “Эрдэнэс агро энд ресорт” ХХК-ийн дүрмийг энэхүү тогтоолын 2-р хавсралтаар баталсугай.
 - g. “Эрдэнэс агро энд ресорт” ХХК-ийг үүсгэн байгуулах, улсын бүртгэлд бүртгүүлэхтэй холбогдсон зардлыг Компани хариуцахыг дурдсугай.
10. Компанийн үнэт цаасны арилжааны дансыг үнэт цаасны брокерийн “Эс Жи Капитал ҮЦК” ХХК-д нээхээр шийдвэрлэсүгэй.
11. Энэхүү тогтоолыг хэрэгжүүлэх болон охин компани үүсгэн байгуулахтай холбоотойгоор Улсын бүртгэлийн ерөнхий газар болон холбогдох татварын албанд бүртгүүлэх, шаардлагатай бусад арга хэмжээг тухай бүр авч ажиллахыг Гүйцэтгэх захирал (Ц.Хүдэрмөнх)-д даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



/Т.ЗОЛБОО/